



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.03.12-03.16

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Хөрөнгө оруулагчид АНУ-ын ган, хөнгөн цагааны импортод тариф тогтоосон мэдэгдэлд бусад улсууд ямар арга хэмжээ авах талаар санаа зовиносон хэвээр байгаа ч тус улсын Ази болон Европын худалдааны гол түнш орнууд тус арга хэмжээнд хүлээцтэй хандаж байна. Мөн энэ долоо хоногийн эдийн засгийн үзүүлэлтүүд зах зээлийн байдлыг зөөлрүүлсэн. Удааширсан өсөлт болон инфляцийн түвшин АНУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөжийг бууруулжээ.

Европ: Европын бүсийн инфляцийн түвшний өндөр үзүүлэлт, худалдааны дайны төлөв байдалтай холбоотой улс төрийн тодорхойгүй байдал болон Их Британий Ерөнхий сайд Тереза Мэйн ОХУ-ыг Их Британийн нутаг дэвсгэр дээр тус улсын тагнуулыг химийнхороорхордуулсан хэмээн үзэж буй геопитикийн хурцадмал байдал зэрэг нь европын компаниудын хувьцааг бага хэмжээгээр арилжигдан, өөр өөр үзүүлэлттэй байхад нөлөөлжээ. Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллагын урьдчилсан таамаглалд Их Британийг дараагийн хоёр жилийн хугацаанд дэлхийн эдийн засгийн өсөлтөөс хоцрон, 20 тэргүүлэгч орнуудаас хамгийн удаан өсөлттэй байна гэж үзсэнтэй холбогдуулан тус улсын зах зээлийн ханш унасан байна.

Япон: Японы үйлдвэрчний эвлэлийн хороо японы хэд хэдэн томоохон компаниудтай тохиролцон сарын цалингийн хэмжээг 2.16%-аар өсгөсөн талаар мэдээлсэн. Ажиллагчид тус өсөлтийг сүүлийн 25 жилд тохиож буй ажилгүйдлийн хамгийн доод түвшин болон компаниудын их хэмжээний ашигтай ажиллагааны хажууд маш бага өсөлт болохыг онцоллоо.

Хятад: Хятад улс санхүүгийн салбарын хяналтыг чангатгах, зээлийн хурдацтай өсөлтийн үед эрсдэлийг хязгаарлах зорилгоор банк болон даатгалын салбарын зохицуулах байгууллагуудыг нэгтгэж байгаа талаар мэдээллээ.

Монгол улс: Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 2 дугаар сарын эцэст 15.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 135.5 (0.9%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.6 (29.0%) их наяд төгрөгөөр өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 2 сард 1.2 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.1 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 73.1 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2017 онд урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 тэрбум америк долларын алдагдалтай гарч, өмнөх оноос 452.4 (74.3%) сая америк доллараар өсжээ. Монгол Улс 2018 оны эхний 2 сард дэлхийн 109 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 1.6 тэрбум америк доллар, үүнээс экспорт 838.4 сая америк доллар, импорт 726.0 сая америк долларт хүрлээ. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 2 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны эцсийнхээс 2.2 хувь, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн байна.

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,990.35	0.91% ▲
Dow Jones	АНУ	24,946.51	-1.54% ▼
S&P 500	АНУ	2,752.01	-1.24% ▼
Nasdaq	АНУ	7,481.99	-1.04% ▼
S&P/TSX	Канад	15,711.33	0.86% ▲
FTSE 100	Их Британи	7,165.14	-0.82% ▼
S&P/ASX 200	Австрали	5,949.40	-0.23% ▼
Nikkei 225	Япон	21,676.51	0.97% ▲
Hang Seng	Хонг Конг	31,501.97	1.63% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	113.49
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	99.29
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	98.23
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	116.15
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.38
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.83
TDBM' 2020	USD	9.3%	108.26

Зах зээлийн хүү

ХҮҮ	Хаалт	ҮоҮ
Libor 1M	1.822	0.07 ▲
Libor 3M	2.202	0.11 ▲
Libor 6M	2.364	0.09 ▲
Libor 1YR	2.615	0.07 ▲
US 6M Bond	1.924	0.06 ▲
US 2YR Bond	2.295	0.03 ▲
US 3YR Bond	2.449	0.01 ▲
US 5YR Bond	2.649	-0.01 ▼
US 10YR Bond	2.850	-0.05 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.03.16	Өөрчлөлт
USD	2,397.19	0.10% ▲
CNY	378.99	0.25% ▲
EUR	2,952.62	0.12% ▲
RUB	41.71	-0.67% ▼
KRW	2.25	0.45% ▲
JPY	22.69	1.07% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,314.24	-0.73% ▼
Мөнгө /spot/	16.34	-1.51% ▼
Зэс	310.75	-0.93% ▼
Нүүрс	97.15	3.49% ▲
WTI газрын тос	62.34	0.48% ▲
Brent газрын тос	66.21	1.10% ▲
Байгалийн хий	2.69	-1.47% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.1	6.90%
Бодлогын хүү	2018.1	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.1	13.63%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.1	12.50%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.1	5.80%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.1	19.40%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.1	10.80%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 53 компанийн 1,007.9 сая төгрөгийн 21,869,492 ширхэг хувьцаа арилжигдав.

“Е-Моние” /НСН/ компанийн хувьцаа 32.22%-аар буюу хамгийн ихээр өсч 1,251 төгрөгт хүрч хаагдсан бол “Ар Баянхангай” /АВН/ компанийн хувьцаа 30.30%-аар буурч 1,150 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 10 удаагийн хэлцлээр 6,313 ширхэг үнэт цаас 627.8 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Харин компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр энэ долоо хоногт арилжаа хийгдээгүй байна.

3-р сарын 16-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,571.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,990.35 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.91%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	6,635
Зах зээлийн үнэлгээ	2,571,399

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,990.35	0.91% ▲
MSE I индекс	10,585.65	2.58% ▲
MSE II индекс	9,944.24	0.80% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	21,251,181	543,569,191
АПУ	239,906	163,188,692
Тавант Толгой	14,242	161,420,930
Говь	1,842	44,523,080
Жинст-Увс	15,234	22,179,725

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Е-Моние	1,251.00	32.22% ▲
Махимпекс	3,500.00	23.24% ▲
Дорнод худалдаа	17,480.00	15.00% ▲
Тавилга	1,587.00	15.00% ▲
Талын гал	13.80	15.00% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ар Баянхангай	1,150.00	-30.30% ▼
Монгол нэхмэл	3,750.00	-22.68% ▼
Оллоо	68.00	-14.99% ▼
Баян-Алдар	580.00	-14.71% ▼
Монгол савхи	900.00	-14.37% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	1,012,375,803
БиДиСек	151,703,131
Ти Ди Би Капитал	134,240,571
Ард капитал групп	120,091,208
Голомт Капитал	103,276,579

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	670.86	713,916
Таван толгой	11,850.00	624,082
МИК	10,000.00	207,093
Говь	23,960.00	186,914
Сүү	245.00	84,280

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Үнэ /төг/	7 хоног	Хүү
1	ZBEG-BD-18/07/20-A0275-15.4	106	10,706,000	101,000	156	15.140
2	ZBEG-BL-24/04/18-A0235-0	1,500	147,300,000	98,200	52	16.081
3	ZBEG-BD-08/02/19-A0106-15.75	610	63,568,100	104,210	156	15.750
4	ZBEG-BD-11/04/19-A0230-18	93	9,402,300	101,100	104	18.000
5	ZBEG-BD-04/04/18-A0267-10.3	2,290	229,000,000	100,000	39	10.300
6	ZBEG-BD-16/10/20-A0342-13.91	100	10,000,000	100,000	156	13.910
7	ZBEG-BD-16/10/20-A0342-13.91	100	10,636,000	106,360	156	13.910
8	ZBEG-BD-17/04/18-A0276-12	400	40,000,000	100,000	39	12.000
9	ZBEG-BL-08/05/18-A0241-0	484	47,369,080	97,870	52	14.670
10	ZBEG-BL-29/05/18-A0304-0	630	59,824,800	94,960	39	11.673

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	587.7	56.6	2018.03.07	2018.03.27	2018.07.02-оос
2	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
3	SUL	Жуулчин дюти фрий ХК	653.6	10,000.0	2018.02.23	ХЭХ бүртгэлийн өдөр	2018.05.01-ээс
4	SUU	Сүү ХК	1,032.0	3.0	2018.02.14	ХЭХ бүртгэлийн өдөр	2018.12.31-ний дотор
5	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	2018.03.18	2018.07.06-аас
6	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	ХЭХ бүртгэлийн өдөр	2018.09.01-ээс
7	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
8	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
9	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
10	MNP	Монгол шуудан ХК	273.5	2.7	2018.02.13	ХЭХ бүртгэлийн өдөр	2018.05.01-ээс
11	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-ээс
12	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-ээс
13	ADL	Адуун чулуун ХК	409.6	130.0	2018.01.24	2018.03.01	N/A
14	UBH	Улаанбаатар хивс ХК	40.4	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
15	TAN	Тахь-ко ХК	128.5	108.0	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
16	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	2018.03.27	2018.04.24-өөс
17	HRM	Гермес Центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-аас

ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
1	HRM	Гермес Центр ХК	2018-02-15	2018-03-07	15:00
2	NEH	Дархан нэхий ХК	2018-02-22	2018-03-17	-
3	BLG	Завханбаялаг ХК	2018-02-27	2018-03-19	10:00
4	VIK	Баян-Алдар ХК	2018-03-09	2018-03-27	10:00
5	ADL	Адуун Чулуун ХК	2018-03-01	2018-03-28	14:00
6	DLH	Эм Эн Ди ХК	2018-03-09	2018-03-28	15:00
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	2018-03-12	2018-04-02	11:00
8	BTG	Баянтээг ХК	2018-03-12	2018-04-02	10:00
9	HRD	Хүрд ХК	2018-02-23	2018-04-04	16:00
10	AZH	Алтайн зам ХК	2018-03-01	2018-04-04	16:00
11	BHL	Бөөний худалдаа ХК	2018-03-05	2018-04-04	13:00
12	HBT	Хөнгөн Бетон ХК	2018-03-13	2018-04-04	17:00
13	MNB	Мон Наб ХК	2018-03-14	2018-04-05	14:00

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
14	GHC	Ган хийц ХК	2018-03-06	2018-04-06	11:00
15	SSG	Сонсголон бармат ХК	2018-03-09	2018-04-06	10:00
16	HUZ	Хөвсгөл усан зам ХК	2018-02-26	2018-04-09	-
17	DAZ	Дорнод авто зам ХК	2018-03-12	2018-04-09	15:00
18	GTL	Гутал ХК	2018-03-18	2018-04-09	15:00
19	ALI	Стандарт Ноос ХК	2018-02-26	2018-04-10	15:00
20	UBH	Улаанбаатар хивс ХК	2018-02-26	2018-04-10	11:00
21	OLL	Оллоо ХК	2018-03-19	2018-04-10	14:00
22	ETR	Э-Транс ложистикс ХК	2018-03-23	2018-04-11	10:00
23	HUN	Увс хүнс ХК	2018-03-23	2018-04-13	9:00
24	BRC	Барилга Корпораци ХК	2018-03-16	2018-04-14	10:00
25	DBL	Даваанбулаг ХК	2018-03-24	2018-04-14	14:00
26	TEX	Техник импорт ХК	2018-03-28	2018-04-16	15:00
27	GOV	Говь ХК	2018-03-27	2018-04-17	14:00
28	HHS	Хөвсгөл хүнс ХК	2018-03-28	2018-04-17	17:00
29	HVL	Хөвсгөл ХК	2018-03-28	2018-04-17	14:00
30	HUV	Хөвсгөл геологи ХК	2018-03-29	2018-04-17	10:00
31	SOR	Сор ХК	2018-03-28	2018-04-18	10:00
32	TGS	Номин Хишиг ХК	2018-03-29	2018-04-18	10:00
33	HHN	Хархорин ХК	2018-03-30	2018-04-18	14:00
34	MIE	Материалимпэкс ХК	2018-03-26	2018-04-20	10:30
35	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	2018-03-27	2018-04-20	16:00
36	NOG	Ачит Алкабы ХК	2018-03-27	2018-04-20	15:00
37	TAV	Тав ХК	2018-03-28	2018-04-20	11:00
38	APU	АПУ ХК	2018-03-29	2018-04-20	15:00
39	HSG	Хөсөг трейд ХК	2018-03-23	2018-04-21	12:00
40	AEL	Анд-Энерги ХК	2018-03-16	2018-04-21	12:00
41	CHR	Увс Чацаргана ХК	2018-03-23	2018-04-22	11:00
42	BNB	Баялаг Налайх ХК	2018-03-30	2018-04-22	15:00
43	MNS	Монноос ХК	2018-03-31	2018-04-23	15:00
44	BDS	Би Ди Сек ХК	2018-04-02	2018-04-23	10:00
45	BHG	Бөхөг ХК	2018-03-23	2018-04-25	10:00
46	ТАН	Тахь-ко ХК	2018-03-30	2018-04-25	10:00
47	EER	Ариг гал ХК	2018-04-02	2018-04-25	17:00
48	TTL	Таван Толгой ХК	2018-04-03	2018-04-26	14:00
49	SUN	Евроази капитал холдинг ХК	2018-03-20	2018-04-27	12:00
50	MIB	Монинжбар ХК	2018-03-20	2018-04-27	11:00
51	GFG	Силк нэт ХК	2018-03-20	2018-04-27	14:00
52	ALD	Азык ХК	2018-03-28	2018-04-27	14:00
53	DZG	Дархан зочид буудал ХК	2018-03-28	2018-04-27	14:00
54	MNH	Монгол Нэхмэл ХК	2018-03-30	2018-04-27	11:00
55	UID	Улсын их дэлгүүр ХК	2018-03-30	2018-04-27	10:00
56	TVL	Тавилга ХК	2018-04-02	2018-04-27	12:00
57	JTB	Женко Тур Бюро	2018-04-04	2018-04-27	10:00
58	JLT	Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК	2018-03-22	2018-04-28	14:00
59	MSC	Монгол Секюритиес ХК	2018-03-23	2018-04-28	13:00
60	TUS	Түшиг Уул ХК	2018-03-29	2018-04-28	14:00
61	HSR	Хасу-Мандал ХК	2018-03-23	2018-04-29	15:00
62	AHH	Хорин хоёрдугаар бааз ХК	2018-03-23	2018-04-30	13:00
63	BSKY	Блюскай секьюритиз	2018-03-30	2018-04-30	18:00
64	ALA	Алтайн Нэгдэл ХК	2018-03-30	2018-04-30	10:00
65	TAS	Эрдэнэт хүнс ХК	2018-03-31	2018-04-30	14:00

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



“Лэндмн ББСБ” ХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн

“Лэндмн ББСБ” ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 3-р сарын 14-нд эхэлсэн. Компани нийт хувьцааны 25 хувийг олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгосон. Нийт босгох таван тэрбум төгрөгийн 2.5 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлэхээр IPO гаргасан ч захиалгын хэмжээ нийлүүлэлтээс 16.5 дахин давсан юм. Эхний өдрийн арилжаагаар “Лэндмн ББСБ” ХК-ийн хоёр ширхэг хувьцаа тус бүр нь 28.75 төгрөгөөр арилжаалагдсан. Компанийн андеррайтераар ажилласан “Мирэ Эссет Секьюритис” ҮЦК-ийн Гүйцэтгэх захирал Н.Цэвэгмид “Арилжааны эхний өдөр авах захиалга өндөр байлаа. Анхдагч зах зээлээс 2.5 тэрбум төгрөг босгохоор зорьж байсан бол өнөөдөр хоёрдогч зах зээл дээр эрэлт 2.5 тэрбум орчим төгрөг байлаа. Энэхүү IPO гарснаар иргэд хувьцааны талаар ойлголт авахаас гадна бусад хувьцаат компанийг судалж байгаа нь хувьцааны арилжаанд эерэг нөлөөтэй гэж харж байна” гэсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ЛэндМН багцын арилжааны тухай тодруулга

Олон нийтэд үнэт цаасаа шинээр гаргаад буй “ЛЭНДМН ББСБ”-ын 20.0 сая ширхэг хувьцааны багцын арилжаа нь 2018 оны 3 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд явагдсан билээ. Энэхүү багцын арилжааг зохион байгуулсан шалтгааныг андеррайтингийн үүрэг гүйцэтгэсэн “Мирэ Эссет Секьюритис Монгол” ХХК-аас “Тус арилжаа нь Lock-up нөхцөлтэй Стратегийн хөрөнгө оруулагчдаас гэрээний нөхцлийн хүрээнд 8 сарын хугацаанд 10 сая ширхэг хувьцааг тусгаарлах (Lock-up) нөхцөлтэйгөөр хийгдсэн болно. Өөрөөр хэлбэл 10 сая ширхэг хувьцаа 8 сарын хугацаанд хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцохгүй болохыг үүгээр мэдэгдэж байна” хэмээн албан тайлбар ирүүлсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ҮЦТХТ: Шинэ дансны тоо 2.5 дахин нэмэгдсэн

Шинээр үнэт цаасны данс нээлгэсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо хоёрдугаар сард өмнөх сараас 2.5 дахин нэмэгдэж, 10 мянга давсан байна. Энэ нь 2016 оны зургаадугаар сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт гэж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв мэдээллээ. Бүтцээр нь харвал нийт данс нээлгэгчдийн 99.8 хувь нь дотоодын иргэд байгаа бол 0.1 хувийг гадаадын иргэд бүрдүүлжээ. Харин үлдсэн хувийг дотоодын болон гаднын аж ахуйн нэгжүүд эзэлсэн байна. Дээрх хугацаанд “Гүүдсек” үнэт цаасны компани хамгийн олон буюу 7000 гаруй данс нээгээд байгаа аж. Түүнчлэн “ЛэндМН” ХК-ийн андеррайтераар ажилласан “Mirae Asset Securities Mongolia” Үнэт цаасны компани 1240 данс нээсэн нь өмнөх сараас 27 дахин өссөн үзүүлэлт болсон байна. Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн гарах чинээгээр энэхүү зах зээлд оролцох иргэдийн идэвх нэмэгдсээр байгааг Монголын Хөрөнгийн бирж онцолж байв. Мөн 2017 онд нийт 859 сая төгрөгийн арилжаа хийсэн нь сүүлийн 26 жилийн дээд үзүүлэлт болсон гэж Монголын Хөрөнгийн бирж мэдээлсэн юм. 2018 он гарснаас хойш арилжааны идэвхээр АПУ, “Тавантолгой”, “Айтүүлс” компаниуд тэргүүлээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Хувьцааны багцын арилжааны үнийн дүнгийн хэмжээг хуучнаар тогтоолоо

СЗХ-ны 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн шаардлагаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/40 дугаар тушаалын дагуу 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/32 дугаар тушаалыг хүчингүйд тооцож, багцын арилжааны үнийн дүнгийн хэмжээг 250.0 сая төгрөг болон түүнээс дээш байхаар эргүүлэн тогтоолоо.

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК нь давхар бүртгүүлэх анхны компанийн хүсэлтийг хүлээн авлаа

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга нь 2013 онд батлагдсанаар үнэт цаасны давхар бүртгэлийг нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн билээ. Үнэт цаасны давхар бүртгэл гэдэг нь гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, дотоодын биржид бүртгүүлж үнэт цаасаа арилжих, дотоодын биржид бүртгэлтэй компани нь гадаадын биржид бүртгүүлэх ажиллагаа бөгөөд тус ажиллагааг зохицуулах нарийвчилсан журам болох “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хамтарсан ажлын хэсэг боловсруулж, Хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар баталсан билээ.

Хорооны энэхүү журамтай нийцүүлэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулах зохицуулалтыг тусган “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2018 оны 02 дугаар сараас эхлэн мөрдөж байгаа юм. Ийнхүү үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдсэний үндсэн дээр, Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д үнэт цаасаа давхар бүртгүүлэх хүсэлтээ 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр ирүүллээ. Энэхүү хүсэлтийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь холбогдох журмын дагуу ажлын 15 хоногт хянан шийдвэрлэнэ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Говь”-ийн борлуулалтын орлого 124.4 тэрбум төгрөг болж, 40.3 хувиар өсжээ

Экспортын хэмжээгээ эрчимжүүлэх бодлого баримталж байгаа “Говь” хувьцаат компанийн борлуулалтын орлого 2017 онд 124.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 40.3 хувиар өссөн байна. Тус компани 2021 онд борлуулалтаа 300 тэрбум төгрөгт хүргэхээр зорин ажиллаж байгаа аж. Монголын Хөрөнгийн биржээс танилцуулсан санхүүгийн тайланд тусгаснаар өнгөрсөн онд “Говь” компанийн цэвэр ашиг 8.4 хувиар өсөж, 17.5 тэрбум төгрөгт хүрчээ. “Говь” компани 2017 оны цэвэр ашгийн 10 орчим хувийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн байна. Нэгж хувьцаанд 220 төгрөг буюу нийт 1.7 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ олгох шийдвэр гаргажээ. Ногдол ашгийг дөрөвдүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн тараахаар болсон байна. Тус компани сүүлийн найман жил тасралтгүй хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг олгож байгаа юм. “Говь” компани 100 хувь ноолууран пальто үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэх, борлуулагч болох зорилт тавин ажиллаж байгаа ажээ. Тус компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 80 гаруй хувиар өссөнөөр 23,960 төгрөг болоод байна. 2017 оны 11 дүгээр сард 34 мянган төгрөгийг давж дээд цэгтээ хүрчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ЗЭС: Экспортын орлогоор тэргүүлэгчийн байр сууриа бататгав

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр Монгол улс оны эхний хоёр сарын байдлаар 838.4 сая долларын бараа бүтээгдэхүүн экспортолж, 726 сая долларын бараа импортоор худалдан авсан байна. Ийнхүү гадаад худалдааны бараа эргэлт эхний хоёр сарын байдлаар 1.6 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 248.1 сая доллараар буюу 18.9%-иар дээшиллээ. Гэхдээ экспортын хэмжээ өмнөх оныхоос ердөө 1.6%-иар өссөн бөгөөд уг өсөлтөд алтны экспорт 41.4 сая доллараар өссөн нь нөлөөлжээ. Харин импортын хувьд өмнөх оны мөн үеийнхээс 47.9%-иар буюу 235 сая доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүн, тэр дундаа дизель түлш, мөн машин механик тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, төмөрлөг зүйлс, тээврийн хэрэгсэл, сэлбэг зэргийн импорт бүгд өссөн нь нөлөөлжээ. Манай улсын гадаад худалдааны тэнцэл эхний хоёр сард ашигтай гарсан ч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 67.4%-иар буурч 112.4 сая долларын ашигтайгаар тэмдэглэгдлээ.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт оны эхний хоёр сард 690.6 сая долларт хүрч, нийт экспортын 82.4 орчим хувийг эзэллээ. Энэ дундаа нүүрсний экспорт мөнгөн дүнгээр 245.4 сая долларт хүрсэн нь эрдсийн экспортын 35.5%, нийт экспортын 29.3%-ийг бүрдүүлсэн байна. Хоёрдугаар сарын нүүрсний экспортыг дангаар нь авч үзвэл 1.25 сая тонн болж өмнөх нэгдүгээр сарынхаасаа 742.8 мянган тонноор багаслаа. Үүнд боомтын нэвтрэлт удааширсан нь нөлөөлсөн ч манай улсын нүүрсний экспорт Хятадын Цагаан сарын баяраар багасдагийг бас дурдах нь зүйтэй.

Эхний хоёр сарын дүнгээрээ нүүрсний экспортын хэмжээ мөн л доогуур байна. Жингээр 3.25 орчим сая тонн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 33.2%-иар, мөнгөн дүн 245.4 сая доллар байгаа нь 25%-иар тус тус бууралттай байгааг илтгэнэ.

Зэсийн баяжмалын экспортын борлуулалт мөн хугацаанд 205.1 мянган тонн буюу 274.6 сая доллараар илэрхийлэгдлээ. Энэ нь жингийн үзүүлэлтээр өмнөх оны мөн үеийнхээс 14.7%-иар доошилсон ч үнийн дүнгээр 11.5%-иар ахисан үзүүлэлт боллоо. Зэсийн хувьд өнгөрсөн онд экспортын орлогын дүнгээр нүүрсний ард орж байсан бол ийнхүү хоёрдугаар сараас эхлэн тэргүүлэгчийн байр сууриа эргүүлэн олж аваад байна. Харин цэвэр зэсийн экспорт багассан дүнтэй гарлаа. Эхний хоёр сарын дүнгээр цэвэр зэсийн борлуулалт жингээр 2.3 мянган тонн, үнийн дүнгээр 15.8 сая доллартай тэнцсэн нь биет үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 20.5%, орлогоор 3.7%-иар доошилсон дүнтэй гарлаа.

Алтны хувьд эхний хоёр сард экспортын орлогоор гуравдугаарт эрэмбэлэгдлээ. Мөн хугацаанд манай улс 1.7 тонн алт экспортолж 72.2 сая орчим доллар олсон нь өмнөх оны мөн үетэй жишихэд биет жингээр 2.2 дахин, үнийн дүнгээр 2.3 дахин дээшилсэн байна.

Түүхий газрын тосны экспорт мөн хугацаанд 1 сая 9.9 мянган баррельд хүрч, 62.6 сая доллартай тэнцсэн нь жингийн тухайд 10.3%-иар буурсан ч үнийн дүнгээр 6.9%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй гарлаа.

Төмрийн хүдрийн экспортын дүн эхний хоёр сарын байдлаар жингийн хувьд нэлээд өссөн ч орлогын үзүүлэлт бууралттай гарлаа. Оны эхний хоёр сарын байдлаар манай улс 932.4 мянган тонн хүдэр экспортлоод байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 30.7%-иар өссөн ч орлогын дүн нь харин 11.9%-иар багасч 39.6 сая доллартай тэнцэв.

Цайрын хүдэр, баяжмалын экспортын өсөлт харин сайн үзүүлэлттэй байна. Мөн хугацаанд цайрын баяжмалын борлуулалт жингээр 21.1 мянган тонн байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 13.1%-иар нэмэгдэж, улмаар орлогын дүн нь даруй 37.9%-иар өсч 37.2 сая орчим долларт хүрлээ.

Жоншны хүдэр, баяжмалын экспортын тухайд ч мөн адил өндөр өсөлт тохиогоод байна. Жоншны экспортын борлуулалт жингээр мөн хугацаанд 49.5 мянган тонн байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 48.7%-иар өссөн бол орлого нь хоёр дахин буюу 103.6%-иар нэмэгдэж 15.7 орчим сая доллартай тэнцлээ.

Хар тугалгын хүдэр, баяжмалын экспорт оны эхний хоёр сарын байдлаар 2.48 орчим мянган тоннд хүрч 6.6 сая долларын үнийн дүнгээр илэрхийлэгдэж буй нь өмнөх оны мөн үеийнхээс жингээр 14.9%, үнийн дүнгээр 7.2%-иар буурсан үзүүлэлт боллоо.

Молибденийн баяжмалын экспортын биет хэмжээ 0.9 мянган тоннд хүрсэн нь 19.2%-ийн бууралттай үзүүлэлт ч гэлээ орлогын дүн нь 7.1%-иар өсч 6.08 сая долларт хүрсэн байна.

Ийнхүү зэс, газрын тос, цайр, жонш, молибдени, гянтболдын хувьд экспортын орлогын үзүүлэлт нь нэлээд өсөлттэй гарлаа. Үүнд зах зээлийн таатай нөхцөл нөлөөлж буй нь дамжиггүй. Хэдий тийм ч эрдэс бүтээгдэхүүний нийт экспорт өмнөх оны мөн үеийнхээс 37.2 сая доллар буюу 5.1%-иар буурсан дүнтэй гарлаа. Үүнд нүүрсний экспорт эхний хоёр сарын байдлаар өмнөх оны мөн үеийн дүнгээс 25%-иар буюу 82 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.

Эх сурвалж: MongolianMinigJournal.com



Дизель түлшний импорт оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 81 хувиар өсжээ

ҮСХ-ны мэдээлснээр II сард дизель түлшний импорт өмнөх сараас 10 хувиар буурч 46 сая ам.доллар болсон байна. Гэхдээ энэ оны эхний хоёр сарын үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 81 хувиар өсөөд байгаа юм. Энэ нь өнгөрсөн хагас жилд дизель түлшний ханш тонн тутамдаа 130-150 ам.доллараар өссөнтэй холбоотой гэж шинжээчид дүгнэсэн. Харин автобензиний импорт өнгөрсөн сард өсөөгүй. УУХҮЯ-ны мэдээлснээр улсын хэмжээнд шатахууны 44 хоногийн нөөцтэй байгаа бөгөөд нөөцийн хомсдол үүсэхгүй ажээ. Шатахууны дундаж ханшийг АИ-92 шатахууны татвар тэглэснийг үл харгалзан I сарын сүүлээс хойш литр нь 30 гаруй төгрөгөөр өсөж 1664 төгрөгийн дундаж үнээр худалдаалагдаж байна. Түгээгч компаниуд үнэ нэмэх шийдвэрээ олон улсын зах зээл дэх ханш чангарсантай холбон тайлбарлаж байгаа юм. Монголын компаниуд "Rosneft"-ээс шатахуун худалдаж авахдаа Сингапурын биржийн ханшид суурилсан үнэ баримталдаг. Тус бирж дэх 92 октантай бензиний ханш өмнөх оны мөн үеэс 20 орчим хувиар өссөн байна. Гэхдээ өнгөрсөн оны сүүлийн хагаст тасралтгүй өсөж байсан ханш I сарын сүүлээс хойш 10 орчим хувиар унажээ. Харин УУХҮ-ийн сайд "шатахууны үнэ нэмэхгүй" гэсэн байр суурь баримталж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

TRQ: 2017 онд орлого өмнөх оноос 21.9 хувиар буурч, 939.8 сая ам.доллар болсон

“Оюу Толгой”-ийн хөрөнгө оруулагч “Turquoise Hill Resources” компанийн нэгж хувьцаанд ногдох ашиг өнгөрсөн оны IV улиралд шинжээчдийн таамгийг давж, гурван цент болжээ. Үүнээс гадна IV улирлын орлого нь 251.7 сая ам.долларт хүрсэн талаар санхүүгийн тайландаа дурдсан байна. Харин 2017 оны хэмжээнд орлого нь 2016 оныхоос 21.9 хувиар буурч, 939.8 сая ам.доллар болжээ. Энэ нь өнгөрсөн онд “Оюу Толгой”-ийн гарц дахь зэс, алтны агууламж буурснаас борлуулалтын хэмжээ багассантай холбоотой юм байна. 2017 онд “Оюу Толгой”-ийн үйл ажиллагааны зардал 711.6 сая ам.доллар болсон нь 2016 оныхоос найм орчим хувиар буурсан дүн болж байгаа аж. Тус компани зардлаа танах арга хэмжээ аваад байгаа юм. “Turquoise Hill Resources” компани 2018 онд ил уурхайн үйл ажиллагаанд 150 сая ам.доллар, гүний уурхайн бүтээн байгуулалтад 1.1-1.2 тэрбум ам.доллар зарцуулахаар төлөвлөж байна. Үүнээс гадна 2018 онд “Оюу Толгой”-ийн зэсийн гарц 125-155 мянган тонн, алтны гарц 240-280 мянган унц байх төлөвтэй байна гэж “Turquoise Hill Resources”-ийн тайланд дурджээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



Entree Resources: 2018 онд Монгол дахь төсөлдөө 1.2-1.5 сая ам.доллар зарцуулна

Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Entree Resources” компани энэ оны I сард “Entree/Oyu Tolgoi” хамтарсан хөрөнгө оруулалттай төслийн техникийн тайланг шинэчлэн танилцуулсан. Үүнд дурдсанаар, “Entree Resources” хувь эзэмшлийнхээ хүрээнд үйлдвэрлэлийн эхний 33 жилийн хугацаанд “Hugo North”-ийн өргөтгөл хэсгээс хүлээж авах бэлэн мөнгөний урсгал 2.1 тэрбум ам.доллар болно гэж тооцож байна. “Entree Resources”-ийн хувьд, өнгөрсөн онд хаалттай хүрээнд 18.5 сая нэгж хувьцаа арилжаалж, нийт 7.6 сая канад долларын хөрөнгө татсан. Харин 2017 оны бүтэн жилийн алдагдал 3.1 сая ам.доллар болсон нь 2016 оныхоос гурван хувиар өсжээ. Мөн 2017 оны эцэс гэхэд бэлэн мөнгөний үлдэгдэл нь 7.1 сая ам.доллар болсон талаар санхүүгийн тайландаа дурджээ. 2018 онд компани Монгол дахь талбайн менежмент, маркетинг зэрэг зардалд ойролцоогоор 1.2-1.5 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн байна. “Entree Resources” болон “Оюу Толгой” ХХК-ийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани нь Оюутолгой төслийн талбай дахь “Hugo North”-ийн өргөтгөл хэсгээс гадна “Heruga” талбайн дийлэнх хэсгийг эзэмшиж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

Уул уурхайн тоног, төхөөрөмжийн борлуулалт сэргэж байна

Уул уурхайн компаниудын зардлаа танах бодлого 2018 онд дуусах төлөвтэй байгаатай зэрэгцээд тоног, төхөөрөмжийн борлуулалт сэргэж байна. Металлын олборлогч голлох компаниудын хөрөнгө зарцуулалт 2013-2017 онд 64 хувиар буурсан талаар “Bloomberg Intelligence” мэдээллээ. Нийт зарцуулалтын 70-80 хувийг бүрдүүлж байгаа металл олборлогч голлох 10 компанийн хөрөнгө оруулалт 2018 онд 12.3 хувиар өсөх төлөвтэй байна. Энэ нь дэлхийн эдийн засгийн өсөлт сайжирч байгаа, түүхий эдийн ханш өндөр байгаа зэрэгтэй холбоотой байж магадгүй гэж “Bloomberg Intelligence”-ийн шинжээчид таамаглалаа. Хэдий тийм боловч нүүрсний салбарын хөрөнгө зарцуулалт 2017 онд 16 хувиар өссөн ч БНХАУ-ын голлох нүүрсний компаниуд зардлаа танаж байгаатай зэрэгцээд энэ онд найман хувиар буурч магадгүй байгаа аж. Хүнд үйлдвэрлэлийн салбарын тоног, төхөөрөмжийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч “Caterpillar” компанийн борлуулалт 2018 онд үргэлжлүүлэн өснө гэж таамаглаж байгаагаар тус компанийн Гүйцэтгэх захирал Жим Амплиби мэдэгдсэн байна. Тэрбээр “Эдийн засгийн голлох индикаторууд эерэг байна” гэж үзжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ING: Түүхий газрын тосны ханш буурах төлөвтэй байна

Түүхий газрын тосны ханш энэ оны хоёрдугаар хагаст 60 ам.доллараас доош бууж магадгүй гэж “ING”-ийн шинжээчид үзэж байна. Азийн зах зээлд нийлүүлэх АНУ-ын газрын тосны хэмжээ тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь олон улсад эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр тогтоох ОПЕС-ийн гишүүн орнуудын хүчин чармайлтад сорилт болж байгаа юм. Өөрөөр хэлбэл Азийн зах зээл дэх АНУ-ын оролцоог хязгаарлахын тулд ОПЕС-ийн зарим орнуудыг хэлцлээс гарахад хүргэж магадгүй гэж шинжээчид үзэж байна. АНУ-ын газрын тосны экспорт өдөрт 1.5 сая баррельд хүрч нэмэгдсэн нь зургаан сарын өмнөхтэй харьцуулахад хоёр дахин өсөөд байгаа бөгөөд гол худалдан авагч нь Азийн орнууд болж байгаа юм. Түүхий газрын тосны ханш 2014 оны дунд үед 115 ам.долларт хүрч байсан ч одоо брент болон Вест Техас төрлийн газрын тосны ханш 65 ам.доллар орчимд хэлбэлзэж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

Shell: Шатах түлшний эрэлт ирэх 20 жилд тасралтгүй өснө

Шатах түлшний эрэлт ирэх 20 жилд тасралтгүй өснө гэж “Shell” компанийн удирдлагууд үзэж байна. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодлогын хүрээнд олон улсад сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж буй. Гэхдээ богино хугацаанд хүнд үйлдвэрүүдийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангах боломжгүй мөн зардал өндөртэй гэж “Shell”-ийн Дэд захирал онцолжээ. “Bank of America”-ийн сүүлд хийсэн судалгаагаар газрын тосны эрэлт 2030-аад оны дунд үед оргилдоо хүрч цаашид буурах төлөвтэй байна. Мөн олон улсын эрчим хүчний агентлагийн тооцоолсноор суудлын автомашины зах зээлд газрын тосны эрэлт 2020 онд дээд түвшинд хүрэхээр байгаа аж.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.